



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2012 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 67

Мандалговь

Тооллогын дүнгийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгөд үзлэг тооллого явуулсан аймгийн комиссын дүнг хэлэлцээд “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 75 дугаар зүйл, 77 дугаар зүйлийн 77,3 Төрийн өмчийн хорооны 2012 оны 46 тоот тогтоолоор батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн тооллого явуулах журамын 3 дугаар зүйлийн 3,5 дахь заалтуудыг тус тус үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг Засгийн газрын албан даалгавар, Төрийн өмчийн хорооны тогтоолоор батлагдсан журмын дагуу орон нутагт сайтар зохион байгуулан явуулсныг тэмдэглэсүгэй.

Хоёр. Бүртгэлд тусгагдаагүй эд хөрөнгийг хавсралт 1-ээр, Дутагдуулсан эд хөрөнгийг хавсралт 2-оор, Маргаантай үндсэн хөрөнгийг хавсралт 3-аар, Илүүдэлтэй, ашиглагдаагүй байгаа хөрөнгийн жагсаалтыг хавсралт 4-ээр тус тус баталгаажуулсугай.

Гурав. Хавсралтад заасан эд хөрөнгийг бүртгэлд авах, шилжүүлэх, худалдах, актлан устгах асуудлыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн баталсан журмын дагуу зохих материалыг бүрдүүлэн аймаг сумдын ИТХ-ын Тэргүүлэгчид тухай бүр хэлэлцэн шийдвэрлэх нь зүйтэй гэж үзсүгэй.

Дөрөв. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж дүнг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд жил бүр танилцуулж байхыг Засаг дарга Д.Чандмань, Өмчийн алба Ш.Батсүх нарт үүрэгболгосугай.

ДАРГА

Ц.МӨНГӨНЦООЖ

01000004



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН АЛБА**

212711 Мандалговь, Сайнцагаан сум
Утас: 70592128, Факс: 70593936

2012. 09. 23 № _____

төнөө _____ -ны № _____ -т

**СҮМЫН ИТХ-ЫН ДАРГА
ЗАСАГ ДАРГА НАРТ**

**Төрийн болон орон нутгийн өмчийн
тооллогын дүнгийн тухай.**

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 01 тоот албан даалгавар. Төрийн өмчийн хорооны 46 тоот тогтоолын дагуу явагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн тооллогын дүнг 2012 оны 07 дугаар сарын 03-ны аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэж тооллогын ажилд үнэлэлт өгч, тооллогын дүнг баталгаажуулан тогтоолууд гаргалаа. Тооллогыг бүх сум байгууллага тогтоосон хугацаанд хийж дүн мэдээгээ ирүүлсэн, аймгийн тооллогын комисс газар дээр очиж барилга байгууламж, газар, тээврийн хэрэгслийг тооллогын дүнтэй тулган үзэж шалган, тулгамсан зарим асуудлыг сум сумдад нь шийдвэрлэх арга хэмжээг зохион байгуулсан байна. Тооллогын материалыг зарим сум байгууллага хугацаа алдаж нэгтгэлд өгсөн, аймгийн төвд газрын асуудлаар маргаанаа шийдвэрлээгүй ганц хоёр байгууллага байсныг эс тооцвол тооллогын ажил хугацаандаа чанартай болсон байна гэсэн дүгнэлтийг Тэргүүлэгчид өгсөн байна. Тооллогын журам зааварт зааснаар тооллогын дүнтэй холбоотой шийдвэрлэх олон асуудал буйг та бүхэн ойлгож байгаа гэж үзэж байна. Ийм учраас дараах зарчмын хэдэн зүйлийг цаашид мөрдөж хэрэгжүүлэхийг нийтэд мэдэгдэж байна.

1. Ямар төрлийн өмчийг аймаг сумдын аль ИТХ нь шийдэх эрх зүйн үндэслэл, журам дүрэмтэй вэ гэдэг асуудал байнга гарч байна. Ийм учираас аймагт шийдвэрлэх ёстой өмчийг сум шийдэх, эсвэл сум өөрөө шийдвэрлэх өмчийг аймагт ирүүлэх явдал нэг биш удаа ганц хоёр биш цөөнгүй сумдад тохиолдож байна. Монгол улсын “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай” хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2, 19.1.3-дах заалт Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 22 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасахад баримтлах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1-дах заалтуудаар аймгийн ИТХ, Тэргүүлэгчид нь

үл хөдлөх болон үндсэн хөрөнгө тухайлбал бүх төрлийн барилга байгууламж, газар, тээврийн хэрэгсэл, худагийг шийдвэрлэж байх, бусад үндсэн болон хөдлөх эд хөрөнгө, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, эд хогшилийг сумын ИТХ,

Тэргүүлэгчид шийдвэрлэж байхаар тогтоосныг огтхон ч анхаарч анзаарагүй байгааг онцлон тэмдэглэж байна. Харин энэ оны Төрийн болон орон нутгийн өмчийн тооллогын үеэр 2000 оны өмнөх бүх худгуудыг сумын ИТХ, Тэргүүлэгчид шийдэх эрхийг шилжүүлсэн билээ. Тэрчлэн төсөл хөтөлбөр, төсөв төлөвлөгөөнд хамрагдан гэрээгээр эзэмшүүлсэн багийн засаг дарга, багийн хүний эмч, цагдаагийн мотоциклийг /аймгийн төсөвтэй шууд харьцдаг байгууллагаас бусад/ гэрээ хэлцэлийнхээ дагуу сум шийдэх эрхийг мөн шилжүүлсэн. Цаашид ч хэвээр үйлчилнэ. Үүнээс хойш энэхүү ялгаа заагийг умарталгүй хэрэгжүүлэхийг сануулах байна.

2. Аймаг сумдын ИТХ, Тэргүүлэгчдээр өмчийн асуудлыг шийдвэрлүүлэхээр тухайн байгууллага асуудал оруулахдаа дор дурдсан зарчмыг заавал хэрэгжүүлэх ёстой байтал түүнийг хэрэгжүүлэх сум байгууллага тун цөөн байгааг дурдаж байна.

а. Ямар ч өмчийг худалдах, актлан устгах шаардлагатай болсон бол байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл дүгнэлт гаргаж өмч эд хөрөнгийн жагсаалтыг /анхны өртөг ашигласан хугацаа элэгдэл хорогдол одоогийн үнэ яах тухай санал, яагаад худалдах актлах болсон шалтгаан худалдах үнийн санал зэргийг хамруулсан/ зураг хөргөөр баталгаажуулж сумын өмч хамгаалах байнгын зөвлөлд өгөх ёстой. Сумын өмч хамгаалах зөвлөл суманд шийдэх өмчийг дүгнэлттэй гаргаж сумынхаа ИТХ-д, аймагт шийдвэрлүүлэх өмчийг сумын өмч хамгаалах зөвлөлийн санал дүгнэлттэй хавсарган засаг даргын зөвшөөрсөн албан бичгээр Орон нутгийн өмчийн албанд ирүүлж байх.

б. Аймагт шийдэх барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, газар 2000 оноос хойших худаганд заавал МХГ-ын байцаагчийн дүгнэлт гаргуулж ирүүлнэ.

в. Зарим тохиолдолд аймагт шийдэх өмчийг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар оруулж тогтоол гарган явуулдаг дутагдал Адаацаг, Баянжаргалан гэх мэт сүмдад олонтой давтагдаж байгааг зогсоох.

г. Аймгийн төвийн шууд харьцдаг байгууллагууд бүх эд хөрөнгийг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж байгаа. Эдгээр байгууллага өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт гаргуулалгүй байгууллагын даргын бичиг ирүүлдэг дутагдлыг дахин гаргахгүй байх.

3. Орон сууцыг хувьчлах худалдан авах асуудлаар олон өрөгдөл аймгийн ИТХ-д шууд ирүүлж байна. Ямар байгууллагын эзэмшилд тухайн сууц байгаатай холбогдуулж оршин суугчид байгууллагадаа өрөгдөлөө гаргах ёстой. Харин байгууллага нь саналаа өрөгдлийн хамт сумын Засаг даргад танилцуулна. Сумын Засаг дарга зөвшөөрч байгаа бол саналаа өрөгдөл, байгууллагын саналын хамт аймгийн орон нутгийн өмчийн албандаа ирүүлэх шат дамжлага зарчмыг дагаж мөрдөх ёстой. Өнөөдөрөөс хойш ийм бурдэл болоогүй өрөгдлийг Засаг дарга, ИТХ, Өмчийн алба хүлээн авахгүй. Ер нь МУ-ын “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай” хуульд зааснаар аймаг бодлого боловсруулж бодлогыг аймгийн ИТХ-аар хэлэлцэн мөрдөх ёстой бөгөөд энэ бодлого гартал шийдвэр гараагүй орон сууцыг худалдах, хувьчлах тухай өрөгдлийг хүлээн авахгүй болохыг мэдэгдэж байна.

4. Төрийн болон орон нутгийн өмчийн тооллогоор данс бүртгэлд тусгагдаагүй орхигдсон өмч бол газрын доорхи шугам сүлжээ байна. Тооллогын комиссын гишүүд ажиллахдаа уг асуудлыг нэг бүрчлэн үзэж зураглал схем гарган хичнээн хэмжээтэйг тогтоож ирэх байсан боловч олонхи сум үүнийг орхисон байна. Иймд 8 дугаар сарын 01-н гэхэд бүх сумд одоо байгаа шугам сүлжээгээ тогтоож зураглал схемээр гаргаж албан бичгээр аймгийн өмчийн албандаа ирүүлэх үүргийг Тэргүүлэгчдийн хуралдааны тэмдэглэлээр та бүхэнд өгөгдсөн болно.

5. Тооллогын үед ТӨ-9 маягтаар бүртгэгдсэн Бүртгэлд тусгагдаагүй байсан үндсэн хөрөнгийг эхний хагас жилийн тооллогоор орлогод авсан байх ёстой. Дэрэнsumaas бусад 14 суманд 750184,5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бий. Үүнд сум шийдвэрлэх хөрөнгийг сумын ИТХ-ын, аймагт шийдвэр хөрөнгийг аймгийн ИТХ-ын шийдвэрээр орлогод авна. Гэтэл аймагт Өлзийт /саравч/, Хулд /ЗДТГ-ын барилга/, Дэлгэрхангай /саравчны материал/ сумдаас бусад сум материал ирүүлсэнгүй. Үүнд: Аймгийн өмчийн алба хагаст жилийн тайлангаар тулгалт хийж хяналт тавина.

6. ТӨ-10 маягтаар бүртгэгдсэн Дутагдуулсан үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгагдсан эд хөрөнгийг байгууллагын дарга, Төрийн сангийн төлөөлөгч ня-бо нар 7дугаар сард багтаан төлүүлж төлбөр барагдуулсан баримтаяа аймгийн өмчийн албандаа ирүүлснээр дуусгавар болгоно. Орлогыг орон нутгийн орлогод оруулах.

7. ТӨ-11 маягтаар бүртгэгдсэн Маргаантай үндсэн хөрөнгийн жагсаалтанд орсон 6 сумын 130,1 сая төгрөгийн өмч байна. Үүнд бүртгэгдвэл зохих өмч бүрэн

бүртгэгдээгүй байгааг тэмдэглэж байна. Өндөршил сумын Баянбөхт хоршооны үл хуваагдах үлдэгдэл хөрөнгийн зарим хэсэг, Өлзийт сумын Гэрээ хоршооноос хувь хүнд худалдсан гэх орон сууцаар ашиглаж буй барилга, аймгийн төвд Урчуудын салбарын конторын барилга гэх мэт.

Дээрх бүртгэгдсэн хөрөнгөөс Эрдэнэдалайн цэцэрлэгийн болон Сайхан-Овоо сумын эмийн эргэлтийн сангийн давхар бүртгэгдсэн хөрөнгийг Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор давхардуулгыг арилгахаар шийдвэрлэсэн бусад нь хэвээр байна. Иймд үндсэн байгууллага нь асуудлаа хэрхэн шийдвэрлэх саналаа дээр дурдсан материалыа бүрдүүлж тухайн шатны хурлаар III улиралд багтаан шийдвэрлүүлсэн байх. /Хулдын асуудлыг энд баримтаар судлаж байна/.

8. ТӨ-12 маягтаар бүртгэгдсэн Илүүдэлтэй, Ашиглагдаагүй байгаа үндсэн хөрөнгийн жагсаалтанд бүртгэгдсэн 135 төрлийн 2,6 тэр бум төгрөгийн өмч байна. Үүнээс сумын ИТХ шийдэх, шийдсэн зүйл байгаа. Харин аймагт шийдвэрлүүлэх өмчөөс ЭМГ, Боловсрол Соёлын газар материалыа бүрдүүлж асуудлаа шийдвэрлүүлсэн. Хулд сумын сургуулийн ДУА 25-41 дугаар бүхий УАЗ-469, ИТХ-ын ДУ 41-90 дугаартай ISUZU маркын жип, Дэлгэрхангай сумын Тэжээл фондын саравч, гүний худгийн усан сан зэрэг асуудал шийдвэрлэгдэж тогтоол гарсан. Говь-Угаал сумын зочид буудлын барилга, Өлзийт сумын Цагдаагийн машин, Цэцэрлэгийн компьютер, ТХДЖТеатрын сурталчилгааны самбар шилжигдсэн болно.

Материалыа ирүүлсэн боловч бүрдэл болоогүй Говь-Угаал сумын хуучин контор, наадмын талбай, Сайнцагаан сумын Элбэрэл буян өрхийн эмнэлгийн барилга, Дэлгэрхангай сумын Тэжээл фондын агуулах, Сайнцагаан суманд буцааж өгсөн багуудад байгаа жижиг барилгууд шийдвэрлэгдсэнгүй.

Ийм учраас ТӨ-11д бүртгэгдсэн бүх үндсэн хөрөнгөд анхаарал хандуулж аймгаар шийдвэрлүүлэхийг нь материалыа бүрдүүлж ирүүлэх, сумаар шийдвэрлүүлэхийг мөн адил материал бүрдүүлж шийдүүлсэн байх замаар III улиралд багтаан тодорхой шийдэлд хүрсэн байхыг мэдэгдэж байна. Үүгээр өмчийн асуудлаар тавьсан санал ирүүлсэн материалд хариу өгч байна.

ДАРГА

Ш.БАТСҮХ

